

43  
72

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ЭХ ОРОН НАМААС  
НЭР ДЭВШИГЧ БАДАРЧИЙН ЭРДЭНЭБАТЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Эрх чөлөөт иргэн

Эрх зүйт төр

Монголын ард түмэн эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахын төлөө тэмцэж байна. Ард түмний энэ түүхэн сонголтыг хэрэгжүүлэхэд Монгол улсын Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг, хэрэгжүүлэх бүрэн эрх чухал ач холбогдолтой юм.

Миний бие ард түмнийхээ эрх ашиг, үндэсний эв нэгдэл, монгол улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг дээдлэн иргэдийнхээ эрх чөлөөг бүрэн эдлүүлэх, эрх зүйт төрийг хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох хөтөлбөрөө сонгогч түмэндээ өргөн толилуулж байна.

**Нэг. Иргэний эрх чөлөөг хангаж, эрх зүйт төрийг төлөвшүүлэх талаар:**

- Иргэний эрх, эрх чөлөөг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлж, эрх тэгш байдал, шударга ёсыг тууштай мөрдөх зарчмыг хэрэгжүүлэх;
- УИХ, Засгийн газрын энэ зорилгод нийцсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана. Нийгмийн шинэчлэлийн аливаа бодлого, арга хэмжээ түшиглэвээс амжилтанд хүрнэ гэж үзнэ;
- Төрийн байгууллагууд ард түмэндээ үйлчилдэг нөхцөлийг бүрдүүлэх;
- Шүүх, хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг чадварлаг, шуурхай, шударга болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлэх;
- Хууль-хариуцлага-хяналтын амин шүтэлцээг бататгах чиглэлийг тууштай баримтлан ажиллах;
- Гэмт хэрэг, эмх замбараагүй байдлын эсрэг тууштай тэмцэж, ард иргэд, ялангуяа залуу үеийг эрх зүйн дархлаатай болгох, тэдний аюулгүй байдал, амгалан тайван амьдрах баталгааг хангах асуудлыг төрийн анхаарлын төвд ямагт байлгах,
- Төр, засгийн байгууллагуудыг хэсэг бүлгийн нөлөөллөөс хамгаалах, олон түмний хяналтанд байлгах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх. Энэ талаар холбогдох хуулиудыг боловсронгуй болгох санал, санаачилга гарган ажиллах;

24  
73

**Хоёр. Иргэдийн аж амьдралыг сайжруулах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах талаар:**

- Амьжиргааны баталгаажих түвшинг эрс дээшлүүлж, цалин тэтгэвэр, тэтгэлгийн доод хэмжээг түүнээс дээгүүр байлгах, төсөвт байгууллагад ажиллагсдын цалинг амьдралын найдвартай баталгаа болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлэх;
- Ажилгүйдэл нь ядуурал, нийгмийн бухимдал, тогтворгүй байдлын эх үүсвэр гэдгийг эш үндэс болгон үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байр бий болгох, хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй боловсрол, мэргэжил эзэмших санал, санаачилгыг дэмжиж ажиллах;
- Нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох, ялангуяа нийгмийн эмзэг давхраа, тахир дутуу иргэдэд тавих анхаарал, халамжийг сайжруулахад анхаарч ажиллах;
- Ард түмнийхээ эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх бодлого хэрэгжүүлэх;
- Орон сууцны хангамжийг сайжруулах, амьдралын таатай орчинг бүрдүүлэх талаар Засгийн газраас явуулж буй бодлогыг дэмжиж, хамтран ажиллах;
- Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, олны хүртээл болгох бүх санал, санаачилгыг хөхиүлэн дэмжих;
- Хүн амын доторх баян, ядуугийн туйлшралыг багасгах талаар цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

**Гурав. Хөгжил дагуулсан эдийн засгийн өсөлтийг түргэсгэх талаар:**

- Эдийн засагт төрийн оролцоог зохистой хэмжээнд бууруулах, хувийн хэвшил давамгайлсан нийгмийн чиг баримжаатай эдийн засгийн бүтцийг тууштай дэмжиж эрх зүйн таатай орчин бүрдүүлэх,
- Иргэн баян бол улс баян байх зарчимд нийцсэн, төсөв санхүү, мөнгө, татвар, гааль, хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжих;
- Үндэсний аюулгүй байдалд нийцсэн, экспорт, дотоод хуримтлалын өсөлтийг урамшуулсан гадаадын хөрөнгө оруулалтыг тууштай дэмжих;
- Төсвийн хуваарилалтад хөрөнгө оруулалт, нийгмийн хамгаалал, цэрэг арми, төрийн захиргааны болон зардлын зохистой харьцааг мөрдөх чиглэл баримтлах;
- Эдийн засгийн бодитой, үр ашигтай өсөлтийг хангахуйц санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхийг эрхэмлэх,

- 85  
74
- Дэд бүтэц, уул уурхай, аялал жуулчлал, мэдээлэл, технологийн салбарыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх;
  - Хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг хөгжүүлэх бодлогыг дэмжих;
  - Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх бодлогыг тууштай баримтлах;

**Дөрөв. Монголын иргэдийн оюун санааны хөгжлийн талаар:**

- Монгол улс, монголын төрт ёсны түүх, соёл урлагийн өвийг судлах, хамгаалах, олон улсын хэмжээнд сурталчлан дэлгэрүүлэх;
- Ард түмний зан заншил, шашин, зан үйлийг уламжлал, шинэчлэлийн хоймсон холбоонд, шинэ зууны агуулгаар баяжуулан хөгжүүлэх;
- Монгол хүний эх оронч үзэл, Монгол Улсын иргэний бахархал, үндэсний ухамсрыг бэхжүүлэх талаар цогц арга хэмжээ санаачлан хэрэгжүүлэх;
- Шинжлэх ухааны нөөц боломж, чадамжийг нийгмийн амьдралын бүх салбарт эрчимтэй ашиглах чиглэлээр монголын эрдэмтдийн шинжлэх ухааны бүтээлийг дэлхийн шинжлэх ухааны эргэлтэд оруулах цогц бодлого явуулах;

**Тав. Иргэний нийгмийн төлөвшлийг эрчимжүүлэх талаар**

- Хүн амын бүлэг, давхраанд төрийн зүгээс адил тэгш анхаарал тавих;
- Нийгмийн дунд давхрааны төлөвшлийг хурдасгах, түүний нийгэм, эдийн засаг, улс төрд гүйцэтгэх үүрэг ролийг өндөржүүлэх бодлого хэрэгжүүлэх;
- Үндсэн хуулинд заасан иргэний нийгмийг байгуулах зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн үүргийг нэмэгдүүлэх,
- Өсвөр залуу, идэр, ахмад үеийнхний алтан холбоос, тэдгээрийн бие биенээ нөхөн гүйцээх залгамж чанарыг хангах бодлого хэрэгжүүлэх;
- Ахмад үеийнхний ажил, амьдралын баялаг туршлага, арга, ухааныг түгээн дэлгэрүүлэхэд санаачлага гарган, идэвхтэй оролцох;
- Залуучуудад боловсрол мэргэжил эзэмших, ажил хөдөлмөр эрхлэхэд бүх талаар туслах, тэдний оюун ухааны хүч нөөцийг мэдээлэл, холбооны технологитой гүнзгий холбосон бодлого хэрэгжүүлэх талаар санаачлага гаргах;
- Жендерийн асуудлыг төрийн түвшинд тавьж, эмэгтэйчүүдийн идэвх санаачилгыг бүх талаар хөхүүлэн дэмжих;

**Зургаа. Экологийн тэнцвэрт байдлыг хангах талаар:**

- Монгол хүний амьдрах орчин-агаар, ус, амьтан, ургамал, газрыг ард түмний эрх ашигт нийцүүлэн зүй зохистой ашиглах,
- Монгол орны байгаль-экологийн тэнцвэрт байдлыг дархлаажуулах, улмаар бүс нутаг, тивийн хэмжээнд өргөжүүлэх бодлого баримталж, үүндээ Нэгдсэн Үндэстний болон Олон улсын байгууллага, бүс нутгийн улс орны төр, засгийн газартай хамтран ажиллах, дэмжлэг авах талаар санаачилга гаргах.
- Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд газар, түүний баялаг, ялангуяа ашигт малтмал ашиглах, эзэмшихтэй холбогдсон харилцаанд гарч буй гажуудал, дутагдлыг таслан зогсоох талаар УИХ, Засгийн газартай хамтран ажиллах;

**Долоо. Үндэсний аюулгүй байдлыг хангах талаар**

- Дэлхий нийтээрээ явагдаж байгаа даяаршлах үйл явцад Монгол улс оролцохдоо өөрийгөө хадгалах бүхий л нөхцлийг бүрдүүлэх бодлогыг залгамжлуулан хэрэгжүүлэх
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд орчин цагийн Монгол улс орны амьдрал, гадаад орчны өөрчлөлтийг харгалзан тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөх.

**Найм. Гадаад бодлогын талаар**

- Монгол төрийн гадаад бодлогын уламжлал, залгамж чанарыг даяарчлалын эриний онцлогтой нийцүүлэн нээлттэй, олон тулгуурт, харилцан ашигтай бие биеэ хүндэтгэсэн зарчмыг баримтлах;
- Ардын дипломатыг хөгжүүлэх бодлогыг үргэлжлүүлэх;
- Мансууруулах бодис, хүн наймаалах зэрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн аливаа илрэл, ард түмнийг гадаадын болон дотоодын террорист халдлагад өртөхөөс хамгаалах, ДОХ-ын халдвар тархахаас сэргийлэх ажилд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

Иргэдийн эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, эрхзүйт төрийн хүчийг Монгол улсаа хөгжүүлэхэд зориулъя.

**Монгол улсын Ерөнхийлөгчид  
Эх орон намаас нэр дэвшигч  
Бадарчийн ЭРДЭНЭБАТ**

